



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2006 оны 4 сарын 12 өдөр

Дугаар 01/35

Улаанбаатар хот

Г Хүн амын амьжиргааны доод түвшинг
батлах тухай

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэг, ҮСГ-ын даргын зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг: Холбогдох аргачлалын дагуу тооцсон “Хүн амын амьжиргааны доод түвшин”-ний 2006 онд мөрдөх хэмжээг хавсралтанд дурьдсанаар баталсугай.

Хоёр: Шинэчлэн тогтоосон “Хүн амын амьжиргааны доод түвшин”-ий талаар холбогдох байгууллагад танилцуулж, нийтэд мэдээлэхийг Статистикийн төлөвлөлт, бодлого зохицуулалтын газар /А.ДЭМБЭРЭЛ/-т даалгасугай.

Гурав: Энэ тушаал гарсантай холбогдуулан “Хүн амын амьжиргааны доод түвшин”-г батлах тухай Үндэсний статистикийн газрын даргын 2005 оны 33 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА

П.БЯМБАЦЭРЭН

Үндэсний статистикийн газрын даргын
2006 оны 4 сарын 12-ны өдрийн
21/25 тоот тушаалын хавсралт

ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИН, БҮС НУТГААР

Бүс нутаг	Хамрагдах аймаг	Амьжиргааны доод түвшин, төг
1. Баруун бүс	1. Баян-Өлгий 2. Говь-Алтай 3. Завхан 4. Увс 5. Ховд	37000
2. Хангайн бүс	1. Архангай 2. Баянхонгор 3. Булган 4. Өвөрхангай 5. Хөвсгөл 6. Орхон	38300
3. Төвийн бүс	1. Говьсүмбэр 2. Дорноговь 3. Дундговь 4. Өмнөговь 5. Сэлэнгэ 6. Төв 7. Дархан-Уул	39000
4. Зүүн бүс	1. Дорнод 2. Сүхбаатар 3. Хэнтий	34800
5. Улаанбаатар	1. Улаанбаатар	42800